



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн эхний үе шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үнэлгээний удирдамжийг хоёрдугаар, үнэлгээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийн үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлөөр 2015 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081100

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
318 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт.



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, ЭМСЯ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Н.Цогзолмаа, ЭМСЯ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Гишүүд:
- Х.Бакытжан, Эрүүл мэнд, спортын яам, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
 - О.Гэрэл, Эрүүл мэнд, спортын яам, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
 - Д.Байгалмаа, Эрүүл мэнд, спортын яам, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
 - Ж.Тунгалаг, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн хэлтсийн дарга
 - О.Баасан, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - Х.Отгонбаатар, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - Ж.Баасансүрэн, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн мэргэжилтэн
 - А.Болдмаа, Нийслэллийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
318... дугаар тушаалын 2 дугаар
Хавсралт

**“Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийн дунд
ХУГАЦААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ УДИРДАМЖ**

Үндэслэл:

Монгол Улсын төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд анхаарч нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйлс болгох талаар арга хэмжээ авч байгаа боловч хүн амын бие бялдрын соёл, эрүүл аж төрөх хэв маягийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Хүн амын дунд биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлага нэмэгдэж байна.

Зорилго:

Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох замаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын хөгжлийн түвшинг олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийх

Үйл ажиллагаа:

1. Үнэлгээний ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний хийх асуумжийг боловсруулах
2. Үйл ажиллагааны дагуу нийслэл болон аймагт томилолтоор ажиллах
3. “Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний ажлын хэсгийн уулзалт зохион байгуулах
4. Үнэлгээний тайланг гаргаж Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах

Үнэлгээ хийх хугацаа:

2015 оны 9 сарын 1-ээс 9 сарын 30-ныг хүртэл

Гарах үр дүн:

Стратегийн хэрэгжилтийн үр дүн гарна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
218 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

**“БИЕИЙН ТАМИР СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦОГЦ ХӨТӨЛБӨР”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ХУВААРЬ**

№	Үйл ажиллагаа	9 сар	10 сар
1	Ажлын хэсгийн тушаал батлах, ажлын хэсгийн нэгдсэн хурал зохион байгуулах		
2	Үнэлгээний санхүүжилт, хөдөө орон нутгийн хуваарь гаргах		
3	Нэгдсэн үнэлгээ хийх аргачлал гаргах, үнэлгээ хийх		
4	Орон нутагт үнэлгээ хийх		
5	Үнэлгээний дүнг нэгтгэх		
6	ЭМСЯ-ын УЗ-ийн хуралд танилцуулах		